

ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨЛТ

Байгалийн болон бусад шалтгаанаар музейд тохиолдож болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлж бэлэн байдлыг хангах, гамшигт нэрвэгдсэн үед авах арга хэмжээ, гамшгийн үеийн ажиллагааны төлөвлөгөө болон зааврыг Та бүхэнд хүргэж байна. Гамшгаас урьдчилан сэргийлэх энэхүү төлөвлөлтийг тус музейд 2004 онд Австрали улсаас сайн дурын ажилтнаар ажиллаж байсан сэргээн засварлагч Сара МсХуг музейн ажилтнуудтай хамтран боловсруулсан юм.

Аливаа музей нь гамшгийн үеийн ажиллагааны тусгайлсан гарын авлагатай байдаг ба музей ажилтнууд, үзэгчид болон цуглуулгаа хохирол багатай авч гарахын тулд урьдчилан сургалт, дадлага байнга хийдэг байна.

Музейн үзмэр, эд өлгийн зүйлийг мэргэжлийн байгууллагад өгч, сэргээн засварлуулдаг боловч анхан шатны арчилгааг музейн ажилтнууд хийдэг бөгөөд гамшигт өртсөн үзмэр, эд өлгийн зүйлтэй бүр их болгоомжтой, зөв харьцах шаардлагатай байдаг.

Гамшиг гэж юу вэ?

Гамшиг гэж хүмүүс ба цуглуулгыг эрсдэлд оруулж буй бүхий л тохиолдлыг хэлнэ.

Гамшиг тохиолдоход нэн түрүүнд анхаарах зүйл:

1. Таны болон бусад хүмүүсийн аюулгүй байдал
2. Музейн сан хөмрөг, цуглуулгын аюулгүй байдал
3. Музейн эргэн тойрон, ойр орчмын аюулгүй байдал

Шуурхай арга хэмжээ

Бэлэн байдал

Болзошгүй гамшиг осолд бэлэн байхын тулд дараах зүйлийг анхаарах. Үүнд:

2. Музейн хонгилын маршрут зам тодорхой, сан хөмрөг болон үзүүлэг дэх үзмэр, эд өлгийн зүйлд хүрэх зам чөлөөтэй байх
3. Гамшиг тохиолдсон нөхцөлд хэрэглэх материал багаж хэрэгсэл хаана байгааг ажилтнууд мэддэг байх
4. Ажилтнууд гамшиг тохиолдсон нөхцөлд хэнд мэдэгдэх ба хэнээс зөвлөлгөө авахаа мэддэг байх

Шууд авах арга хэмжээ

Дараах асуултад хариулж, нөхцөл байдалд үнэлгээ өгөх

Ямар гамшиг тохиолдсон, юунаас үүсэлтэй?

Танд болон ойр орчмын хүмүүст аюултай юу?

Музейн цуглуулгад аюултай юу?

Гамшиг болсон талаар шаардлагатай хүмүүст яаралтай мэдэгдэх

Ж:

- Музей нээлттэй цагаар үзмэрийн танхимд гамшиг болсон бол үзмэр харагчид яаралтай мэдэгдэж, үзэгчдийг холдуулах
- Захиралд мэдэгдэхээр хэн нэгийг илгээх
- Гал гарсан тохиолдолд харуулд юуны өмнө өмнө мэдэгдэж, Онцгой байдлын газар руу яаралтай утасдах буюу утасдуулах, дараа нь барилгаас гарах хэрэгтэйг хүмүүст хэлэх

- Авран хамгаалах багийн гишүүдэд мэдэгдэх (эрдэм шинжилгээний ажилтан, сан хөмрөгч ба бүртгэл мэдээллийн санч)

Богино хугацаанд авах арга хэмжээ

Нөхцөл байдлыг тогтворжуулах

Үзмэр, эд өлгийг хөдөлгөхгүйгээр гэмтэхээс сэргийлэх дараах арга хэмжээг авах. Үүнд:

- Хуванцар эд өлгийг хучих
- Гоожиж буй усны дор сав тосох, ойр орчмын усыг том шүүрээр шүүрдэж үзмэрт ус хүрэхээс сэргийлэх

Үзмэр, эд өлгийг байгаа газарт нь хамгаалж чадахгүй болон үзмэрт илүү их гэмтэл учруулахгүйгээр зөөж чадах тохиолдолд үзмэрийг хөдөлгөх

Аюул учруулж буй эх үүсвэрийг арилгах. Ж: Усны хоолойгоос ус алдаж байвал арга хэмжээ авахуулах.

Зөв арга хэмжээ авч чадахгүй эргэлзэж байвал зөвлөлгөө ав.

Урт хугацааны арга хэмжээ

Нөхцөл байдлыг дахин үнэлэх

Гамшиг аль хир их байна вэ? Арга хэмжээ авахад хэдэн хүн шаардлагатай вэ? Ямар төрлийн үзмэр, эд өлгийн зүйл хэрхэн нэрвэгдсэн бэ? Ямар материалаар бүтээгдсэн үзмэрүүд хамгийн их эмзэг, арчилгаа илүү шаардах вэ?

- Бөс даавуун эдлэл, цаас зэрэг материалууд будаг болон бэхтэй байдаг тул норсон тохиолдолд урсаж, бусад үзмэрт толбо тогтоож мэднэ.
- Цаас, арьс шир зэрэг шингээгч материал усанд удаан байх тусмаа илүү их гэмтдэг ба металл, шил зэрэг шингээдэггүй материалд өөрчлөлт орохгүй.

Танай музей ямар үзмэр, эд өлгийн зүйл хадгалдаг вэ?

Бараг бүх үзмэр, эд өлгийн зүйл нойтон үедээ илүү эмзэг хэврэг байдаг тул анхаарал арчилгаа илүү их шаардагдана. Галд өртсөн үзмэрүүд бүр ч хэврэг болдог.

Янз бүрийн материалаар бүтээгдсэн үзмэр, эд өлгийн зүйлийг өөр өөр аргаар арчилдаг.

Бөс даавуун эдлэл

Бөс даавуу эдлэл буюу хувцсыг тэнийлгэж, шингээгч цэвэр материалаар бүрсэн хавтгай гадаргуу дээр тавина. Шаардлагатай бол олон давхар буюу нимгэн материалаас бүтсэн хувцасны завсар шингээгч тусгаарлагч материал хийнэ. Үзмэрийн дээр мөн шингээгч материал тавина. Шингээгч материал норсон тохиолдолд сольж, хөгц ургасан эсэхийг шалгаж, шаардлагатай бол арчилгаа эмчилгээ хийнэ.

Амьтан ба ургамлын үзмэр

Үзмэр, эд өлгийн зүйлийг шингээгч цэвэр материалаар бүрсэн хавтгай дээр тавих ба гурван хэмжигдэхүүнтэй үзмэр бол үзмэр, эд өлгийн зүйлийн хэлбэрийг хэвээр хадгалахын тулд мөн материалаар бүрсэн тулгуур дээр байрлуулна. Шингээгч материалын завсар үзмэрийг хавчуулах ба үзмэрийн

дундуур мөн дээрх материалыг хийнэ. Шингээгч материал норсон тохиолдолд солихын зэрэгцээ хөгц ургасан эсэхийг шалгаж, шаардлагатай бол арчилгаа эмчилгээ хийнэ.

Мод

Модон эдлэлийг шингээгч цэвэр материалаар бүрсэн саванд хийх ба ингэхдээ үзмэрийн хэсэг бүрийг агаарын солилцоотой байхаар тавихыг хичээнэ. Хайрцаг саванд чийг шингээгч тавьж, модны илүүдэл чийгийг шингээж сэврээнэ. Ялангуяа будагтай модон үзмэртэй болгоомжтой харьцах хэрэгтэй. Мөн хөгц ургасан эсэхийг шалгаж арчилж байна.

Арьс шир

Арьс ширэн эдлэлийг шингээгч цэвэр материалаар бүрсэн хавтгай дээр аль болох агаарын солилцоотой орчинд тавих ба шаардлагатай бол нэмэлт шингээгч материал ашиглаж, үзмэрийн хэлбэрийг хадгална. Шингээгч материал нь арьс ширний илүүдэл чийгийг өөртөө шингээж, үзмэрийг сэврээнэ. Гэвч хөгц ургасан эсэхийг шалгаж арчилж байх хэрэгтэй.

Цаас

Цаасыг хатаахын тулд өлгөж болох ба ялангуяа олон цаасан үзмэртэй бол өлгөх нь зай талбай хэмнэх бололцоо олгоно. Цаас тус бүрийг тусад хатаана. Харин хавтгайгаар нь хатаах тохиолдолд цаасны завсар шингээгч материал буюу цаас хавчуулна. Үдэгдсэн ном зэргийг сэнсээр үлээлгэх буюу завсар нь мөн шингээгч материал хавчуулна. Хөгц ургасан эсэхийг шалгаж, арчилж байх хэрэгтэй.

Уран зураг

Уран зургийг хоёр талаас нь агаарын солилцоо явагдаж, хатахаар хөндий байрлуулна. Шаардлагатай тохиолдолд үзмэр гэмтэхээргүй бол хатаахаасаа өмнө зургийг жаазнаас нь авах хэрэгтэй.

Шил, шаазан ваар

Үзмэр, эд өлгийн зүйлийг агаарын их солилцоо бүхий орчинд шингээгч цэвэр материалаар бүрсэн, цэвэр хавтгай дээр тавина. Шингээгч материалаар чийгийг арчиж, үзмэрийг хатаана.

Металл

Ихэнх металл үзмэр, эд өлгийг шингээгч цэвэр материалтай хавтгай дээр хамгийн их агаарын солилцоо явагдахаар тавих ба толбо суулгах эрсдэлтэй усны дуслыг шингээн авч сэврээнэ. Металл үзмэр нь норхоосоо илүүтэй чийгтэй бол хурдан зэвэрдэг тул их норсон үзмэрийг цэвэр устай саванд хийж, Соёлын өвийн төвд аваачиж өгнө. Мэргэжлийн сэргээн засварлалтын төв хэд хэдэн химийн ванны тусламжтайгаар үзмэрийг хатаадаг.

Анхаарна уу!

Хэрэв их хэмжээний гамшгийн үед нэг дор олон үзмэр, эд өлгийн зүйлд арчилгаа хэрэгтэй бол тэдгээрийг гялгар уутанд хийж, хөлдөөгөөд дараа нь арчилж болно. Гэхдээ хөлдөөж болохгүй зааны яс, яс шүд зэрэг органик болон органик бус үзмэрүүд бий. Мөн хөгц тогтсон үзмэрийг хөлдөөж, хөгцийг устгах арга байдаг. Гэхдээ хөлдөөж болох үзмэр эсэхийг мэргэжлийн байгууллагаас асуух хэрэгтэй.

Жич: Шингээгч материал гэдэг нь гар нүүрийн алчуур, уусгагч цаас, цаасан алчуур бөгөөд эдгээр материал байхгүй нөхцөлд бусад цаас, бөс даавууг хэрэглэж болно.

Гамшгийн үеийн ажиллагааны төлөвлөгөө

Шаардлагатай утасны жагсаалт

Яаралтай холбогдох ажилтнууд.....1
Яаралтай дуудлагын утас..... 1

Гамшгийн үеийн ажиллагааны төлөвлөгөө

Гамшгийн үеийн ажиллагааны зохицуулагч.....2
Шуурхай баг2

Гамшгийн үеийн ажиллагааны заавар

Нүүлгэн шилжүүлэлт шаардлагагүй тохиолдол...3
Нүүлгэн шилжүүлэлт шаардлагатай тохиолдол4

Шаардлагатай утасны жагсаалт

Яаралтай холбогдох ажилтнууд

Нэр	Хариуцах ажил	Утасны дугаар
	Захирал	
	Ерөнхий зохион байгуулалт	
	Сан хөмрөг	
	Сан хөмрөгийн бүртгэл	
	Үзмэрийн танхим	
	Аж ахуйн хэсэг	

Яаралтай дуудлагын утас

Гал команд	
Цахилгаан шугам сүлжээ	
Дулаан шугам сүлжээ	
Соёлын өвийн төв (Сэргээн засварлалтын мэргэжлийн байгууллага)	

Гамшгийн үеийн ажиллагааны төлөвлөгөө

Энэхүү төлөвлөгөөнд тус музейд тохиолдож болзошгүй гэнэтийн аюул гамшгийн үед ажилтнууд, үзэгчид болон цуглуулгад учирч болох хохирлыг

хамгийн бага түвшинд байлгахын тулд авах арга хэмжээ, ажиллагааны талаар төлөвлөсөн болно.

Гамшгийн үеийн ажиллагааны зохион байгуулагч

Аюул гамшгийн үеийн ажиллагааны зохицуулагч нь энэхүү төлөвлөгөөг хариуцаж, шинэчлэн захирлаар батлуулж байна. Тэрээр томоохон хэмжээний аюул гамшгийн үед авран хамгаалах багийг удирдаж, арга хэмжээ авах эрхтэй бөгөөд багахан хэмжээний осол гарсан газрын эрдэм шинжилгээний ажилтан, сан хөмрөгч нар эзгүй үед авран хамгаалах ажиллагааг мөн хариуцна. Зохицуулагч тухайн цуглуулгыг хариуцсан эрдэм шинжилгээний ажилтан, сан хөмрөгч нарын зөвлөлгөөг авсны үндсэн дээр тодорхой асуудлыг шийдвэрлэх ба захирал, захирлыг эзгүйд дэд захирал буюу менежерээс зөвлөлгөө авахаас гадна, шаардлагатай тохиолдолд гаднаас мэргэжлийн туслалцаа авч болно. Зохицуулагч эзгүй үед буюу багахан хэмжээний ослын үед тухайн эрдэм шинжилгээний ажилтан, сан хөмрөгч нар зохицуулагчийн үүрэг гүйцэтгэгч болно.

Шуурхай баг

Авран хамгаалах шуурхай багт эрдэм шинжилгээний ажилтан, сан хөмрөгч, бүртгэл мэдээллийн санч нар багтана. Тэд музейн сан хөмрөгийг гамшиг гарсан даруй хэрхэн авран хамгаалах сургалтад хамрагдсан байх ба зохицуулагч буюу зохицуулагчийн үүрэг гүйцэтгэгчийн удирдлага доор шуурхай арга хэмжээ авна.

Гамшгийн үеийн ажиллагааны заавар

Нүүлгэн шилжүүлэлт шаардлагагүй тохиолдол

1. Бүсчилсэн хамгаалалт

Олон нийтэд зориулсан үйлчилгээний талбай гамшигт өртсөн үед үзмэрийн танхимын үзмэр харагч нар тухайн талбай руу хүн оруулахгүй хаах үүрэгтэй. Зөвхөн захирал, менежер-зохицуулагч, шуурхай баг, эсвэл захирал, зохицуулагч болон тэдгээрийг орлон гүйцэтгэж буй ажилтан нар оруулах шаардлагатай гэж үзэж, зөвшөөрөл авсан хүмүүсийг оруулахыг зөвшөөрнө.

2. Үндсэн ажиллагаа

Шуурхай баг нь осол гамшигт нэрвэгдсэн талбайд зохицуулагч буюу түүний үүрэг гүйцэтгэгчийн заавраар ажиллана.

1. Байдлыг тогтворжуулах

- Осол гарсан газар буй үзмэр, эд өлгийг хамгаалах арга хэмжээ авах. Ингэхдээ осолд өртсөн эд өлөгт аль болох гар бага хүрэх
- Үзмэр, эд өлгийн зүйлийг байгаа газар нь хамгаалах боломжгүй нөхцөлд тэдгээрт илүү их гэмтэл учруулахааргүйгээр зөөнө.
- Боломжтой бол гамшгийн эх үүсвэрийг арилгах. Жишээлбэл: усны крантыг хаах г.м

5. Гамшгийн байдлыг баримтжуулах

- Гамшиг осол болсон газрын байдлыг нарийвчлан баримтжуулах. Ингэхдээ үзмэр, эд өлгийн зүйл гамшиг болохоос өмнө хаана байсныг

тодруулж болохуйцаар сайн дүрсжүүлэн (гэрээ зураг авах зэргээр) баримтжуулна.

- Авран хамгаалах ажиллагааны үед үзмэр, эд өлгийн зүйлийг хаана нүүлгэн шилжүүлсэн тухай бүртгэл тэмдэглэл хөтөлнө.

6. Авран хамгаалах ажиллагааг явуулах

Үзмэр, эд өлгийн зүйлийг аюулгүй цэвэр, хуурай газар нүүлгэхдээ тэдгээрийн хэсэг нэг бүрийг бөөнд нь цуг тавьж, салгахгүй хадгалах ба шаардлагатай бол сэргээн засварлахад өгөх, зөвлөлгөө авах.

Авран хамгаалах ажиллагааны заавар

Нүүлгэн шилжүүлэлт шаардлагатай тохиолдол

Нүүлгэн шилжүүлэлт зайлшгүй шаардлагатай нэг гол гамшиг бол галын аюул юм.

1. Тандалт ба нүүлгэн шилжүүлэлт

Хэрэв музейн ажилтан гал гарч байгааг өөрөө мэдэх буюу бусдаас мэдсэн тохиолдолд дараах зүйлийг яаралтай хийх ёстой. Үүнд:

- Харуулд мэдэгдэх, боломжтой бол Онцгой байдлыг газар руу утасдах
- Ойр орчмын хөрш газруудад мэдэгд
- Барилгаас нүүн шилжүүлэлт хийх
- Дараагийн зааврыг хүлээх

Шуурхай багийнхан зохицуулагчийн удирдлага дор Сүхбаатарын талбайн захад цуглана.

2.Музей руу эргэж орох аюулгүй байдал

Музейд эргэн орох үед харуул нэрвэгдсэн талбай руу зөвхөн захирал, зохицуулагч, түүний баг, зөвшөөрөлтэй хүмүүсийг оруулна.

3. Авран хамгаалах ажиллагаа

Барилга аюулгүй болсон үед шуурхай баг гамшигт нэрвэгдсэн талбайд орж, зохицуулагч буюу түүнийг орлож буй ажилтны удирдлага дор ажиллана.

1. Гамшиг гарсан газар ажиллах

- Осол гарсан газар буй үзмэр, эд өлгийг хамгаалах арга хэмжээ авах. Ингэхдээ осолд өртсөн эд өлөгт аль болох гар бага хүрэх
- Үзмэр, эд өлгийн зүйлийг байгаа газар нь хамгаалах боломжгүй нөхцөлд тэдгээрт илүү их гэмтэл учруулахгүйгээр зөөнө.
- Боломжтой бол гамшгийн эх үүсвэрийг арилгах. Жишээлбэл: усны крантыг хаах г.м

2.Гамшгийн байдлыг баримтжуулах

- Гамшиг осол болсон газрын байдлыг нарийвчлан баримтжуулах. Ингэхдээ шаардлагатай бол үзмэр, эд өлгийн зүйл гамшиг болохоос өмнө хаана байсныг тодруулж болохуйцаар сайн дүрсжүүлэн баримтжуулна.
- Авран хамгаалах ажиллагааны үед үзмэр, эд өлгийн зүйлийг хаана нүүлгэн шилжүүлсэн тухай бүртгэл тэмдэглэл хөтөлнө.

7. Үзмэр, эд өлгийн зүйлийг аюулгүй, цэвэр, хуурай газар нүүлгэхдээ тэдгээрийн хэсэг нэг бүрийг бөөнд нь цуг тавьж салгахгүй хадгалах ба шаардлагатай бол сэргээн засварлахад өгөх, зөвлөлгөө авах.

Гамшгийн үед хэрэглэгдэх материал, багаж хэрэгсэл

Материал, багаж хэрэгсэл	Зориулалт
Хувин	Ус хийх
Шүүр	Цэвэрлэгээ хийх, ус зайлуулах
10 литрийн сав	Ус тосох, цэвэрлэгээ хийх
Тоосны гөвүүр ба сойз	Цэвэрлэгээ хийх
Яаралтай арга хэмжээний заавар	Лавлах ном
Уртасгагч	Цахилгааны эх үүсвэрт хүрэх
Эсгий туурга зэрэг	Гал цохиж унтраах
Гал унтраагуул СО 2	Бага хэмжээний гал унтраах
Хогны уут 20 боодол	Материал багажийг зөөх
Резинен бээлий	Эрүүл ахуйн үүднээс
Тэмдэглэгээ хийх маркер	Үзмэр, эд өлгийн зүйл зэргийг зөөх

	тээвэрлэх
Скоч	Наах, бэхлэх
Цахилгааны самбар (цит)	Цахилгааны зөөврийн эх үүсвэр
Хайч	Скоч зэргийг хайчлах
Том шүүр	Цэвэрлэгээ хийх
Гар чийдэн ба зай	Ток тасрахад
Усны урт хоолой (янз бүрийн)	Бага зэрэг алдаж байгаа усыг гадагшлуулах
Хутга	Хуванцар, наалт зэргийг таслах
Алчуур	Цэвэрлэгээ хийх
Бичгийн цаас тавих тавиур ба хавчаар	Үзмэр, эд өлгийн зүйлийн хөдөлгөөнийг бүртгэх тэмдэглэх

Музейн үзмэр, эд өлгийн зүйлийг зөөсөн бүртгэл

Огноо:

Сан хөмрөг/Байршил.....

Хувийн дугаар	Нэр	Бүтэц, онцлог шинж	Байнгын байршил	Лавлагаа: Модон хайрцаг/цаасан хайрцаг	Шинэ байршил	Чанар байдал	Тайлбар

Ашигласан материал.

1. Sara McHug. Disaster Plan National Museum of Mongolian History. UB.2004. p.156-167.

2. Kims Disaster Booklet. Disaster Planning for Cultural Collections. 2002

Орчуулсан: **Д.Бумаа Ph.D, дэд профессор**
МҮМ-н Музей судлалын мэргэжил арга зүйн төвийн дарга
Музейн мэдээлэл